



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 3 сарын 17 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

### III ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 16.00 цагт Төрийн ордон дахь “Шадар сайдын хурлын өрөө”-нд 80 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Олон улсын худалдааны хорио цээрт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар

*Мал, эмнэлгийн ерөнхий газрын дарга  
Д.Батчулуун*

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, татан авалтын талаар

*Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дэд дарга  
Д.Уранзаяа*

3. Бусад



## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Гадаад харилцааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Баасандорж, Гаалийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дэд дарга Д.Уранзаяа нарт:*

1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, татан авах ажлыг шуурхай зохион байгуулж, тасалдал, хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

*Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт:*

2.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээнд зарцуулсан төсөв, хөрөнгийн зарцуулалтын талаар нэгдсэн тайлан мэдээлэл боловсруулж 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулах;

*Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Сангийн сайд Б.Жавхланд:*

3.1. Олон улсын ачаа тээврийн нөхцөл байдал хүндэрч, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал, хомсдол, үнийн өсөлт үүсэх эрсдэлтэй нөхцөл байдлыг харгалзан үзэж эм ханган нийлүүлэгч, дотоодын үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээлд хамруулах зэрэг бодлогын дэмжлэг үзүүлэх боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

*Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан, Мал, эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Батчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:*

4.1. Малын гоц халдварт шүлхий өвчний халдварын голомтыг хяналтад авах, тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

4.2. Хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт иргэдийн зорчих хөдөлгөөн, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

4.3. Аймаг, нийслэлийн мал, эмнэлгийн газрууд шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хувцас хэрэгслийн нөөцийг тогтмол бүрдүүлж, хяналт тавих;

4.4. Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах;



4.5. Шүлхий өвчний халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд холбогдон гарсан зардлыг аймаг, орон нутгийн батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх.

4.6. Олон улсын болон хил гаалийн нөхцөл байдалтай холбогдуулан стратегийн болон өргөн хэрэглээний хүнс, түүхий эдийн хомсдол, тасалдал үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

*Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан нарт:*

5.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албанд /Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв/ даалгах. Үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллээр Улсын онцгой комиссыг тогтмол хангаж ажиллах;

5.2. Коронавируст халдвар /Ковид-19/, түүний шинээр гарч буй хувилбар, учирч болох эрсдэлийн талаарх судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлж, Засгийн газар, Улсын онцгой комисст тогтмол мэдээлэл хүргүүлэх;

*Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Т.Гантулга нарт:*

6.1. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, нөөцөд тогтмол хяналт тавьж үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхээс урьдчилан сэргийлэх, чингэлэг тээврээр татан авч байгаа түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавих;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүүд даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ